

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№.../

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Хөх Ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Хөх Ган” хувьцаат компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан тайланг хангалттай гэж үзэссүгэй.

Хурлын дарга



“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ *1*

Улаанбаатар хот

Аудитын хорооны тайланг батлах тухай

“Хөх Ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Хөх Ган” ХК-ийн Аудитын хорооны тайланг хангалттай гэж үзэссүгэй.
2. “Хөх Ган” ХК-ийн Аудитын хорооны 2014 оны тайланг хавсралтаар баталсугай.

Хурлын дарга



Хөх Ган ХК-ийн 2015 оны 04 сарын 30-ны өдрийн
хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №.᠘ тоот тогтоолын хавсралт

**“ХӨХ ГАН “ХК-ИЙН ТУЗ-ИЙН
АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ**
2015 оны.....сарынөдөр

“Хөх Ган” ХК Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороо нь Компаний тухай хуулийн 81,4 дүгээр зүйлийн дагуу үйл ажилагаагаа явуулсан бөгөөд “ХӨХ ГАН “ХК –ний санхүүгийн тайланд 2014 оны 12 дугаар сарын 31 байдлаар аудит хийж дүгнэлт гаргалаа.

“ХӨХ ГАН “ХК нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан ,санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бэлтгэгдсэн байна .

“ХӨХ ГАН” ХК нь Ай Жэй Эй Эйч –Аудитын газраар 3-н жил санхүүгийн үйл ажилгаанд аудит хийлгэжээ.

2014оны байдлаар их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ ,хэлцэл хийгдээгүй гэж үзэв.

“Хөх Ган “ХК -ий НББ –ийн бодлогын баримт бичгийг боловсруулж ,санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн авлага,өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл ,тайлан журналыг тогтмол хөтөлж , тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажллах нь зүйтэй байна.

Байгууллага авлага, өглөгийг санхүүгийн тайланд тусгах талаар бодлогын баримт бичиггүйн улмаас олон жил хуримтлагдан бүртгэгдсэн бараа материал ,авлагыг найдваргүй авлагын нөөц сан бүрдүүдэх шаардлагтай байна .

Иймд цаашид авлагын бүртгэлийн талаар бодлогын баримт бичигт тусгаж найдваргүй авлагын нөөц үүсгэж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Аудитын хорооны дарга :  /С.Алтанцэцэг/

“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№.᠑

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Хөх Ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Хөх Ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр

1. Б.МӨНХТӨР
2. Ц.БАТБАЯР
3. Ц.БАТБОЛД
4. Д.ЭНХБАТ
5. Б.ЛХАГВАДОРЖ
6. Б.МЯНГАНБАЯР

Хараат бус гишүүдээр

7. Д.ДАВГАДОРЖ
8. Х.БАТХИШИГ
9. Д.ЧИНБАТ нар тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга



“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№.1

Улаанбаатар хот

ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дах заалтыг үндэслэн “Хөх Ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Хөх Ган” ХК-ийн ТУЗ болон Гүйцэтгэх Удирдлагын 2015 оны төсвийг 16,600,000 төгрөгөөр тогтоосугай.

Хурлын дарга



“ХӨХ ГАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 5.

Улаанбаатар хот

Компанийн ногдол ашгийн тогтоолыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 2 дах заалтыг үндэслэн “Хөх Ган” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. ТУЗ-ийн 2014 оны ногдол ашгийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

